

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийн тухай

Монгол Улсын Засгийн газраас гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний нэг нь Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж, хэрэгжүүлж ирлээ.

Энэ хүрээнд Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс болон Бүгд Найрамдах Чех Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулан, иргэдийн шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоох эрх үүсгэх, шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг харилцан шилжүүлэх, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах талаар харилцан тохиролцон, хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКУ)-ын Засгийн газар 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай анхны хэлэлцээрийг байгуулсан бөгөөд БНКУ-ын Засгийн газраас 2014 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр хэлэлцээрийг цуцлах санал ирүүлсний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 304 дүгээр тогтоолоор энэхүү хэлэлцээрийг цуцалсан. Хэлэлцээр цуцлагдсанаар хоёр улсын иргэд, ялангуяа Монгол Улсын харьяатаас гарсан казах иргэдийн Монгол Улсад хөдөлмөрлөсөн, шимтгэл төлсөн хугацааг нөгөө талд тооцохгүй болж тэтгэвэр авах эрх нь үүсэхгүй байх, мөн бага хэмжээний тэтгэвэр тогтоогдох нөхцөл бий болсон.

Иймээс хоёр улсын иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах, тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор БНКУ-ын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яам болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, хэлэлцээр шинээр байгуулах асуудлаар Монгол Улсын Засгийн газар 2018 оноос шинжээчдийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж 17 удаагийн хэлэлцээ хийгээд байна.

Түүнчлэн, Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол Улс, БНКУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдаан (VI-IX), түүний мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хоёр талаас нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шуурхай байгуулах талаар тэмдэглэсэн болно.

Монгол Улсын харьяатаас 1994-2018 онд 61.6 мянган казах иргэн гарсан тоон мэдээлэл байдаг. Түүнчлэн 2001-2017 онд Монгол Улсын харьяатаас гарч БНКУ-ын иргэн болсон боловч буцаж Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон 1.7 мянган иргэн байна.

Гадаад харилцааны яамны мэдээллээр 2023 оны байдлаар БНКУ-д Монгол Улсын 8,036 иргэн оршин сууж байгаагаас 3,115 иргэн албан ёсоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээллээр Монгол Улсад БНКУ-ын 564 иргэн оршин сууж байна.

“Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн төсөлд Үндсэн ойлголтууд,

Хамаарах этгээд болон хамрах хүрээ, Тэтгэвэр тогтоох болон олгох, Ажилласан (даатгуулсан) хугацааг нэгтгэн тооцох, Тэтгэврийг шилжүүлэх, Талуудын хамтын ажиллагаа, Хүний хувийн мэдээлэл, Төгсгөлийн заалтууд гэсэн 8 зүйлийг тусгасан бөгөөд хоёр улсын иргэдэд тэтгэвэр тогтоож олгоход дараах зарчмыг баримтлахаар тохиролцсон. Үүнд:

- Монголын талаас тэтгэврийн даатгалын сангаас олгох газрын доор, хөдөлмөрийн халуун, хортой, хүнд нөхцөлөөр эрт тогтоохоос бусад өндөр насны тэтгэвэр, Казахстаны талаас өндөр насны тэтгэврийн болон хуримтлалын тэтгэврийн төлбөр гэсэн тэтгэврийн төрлийг хамааруулах;
- Хоёр улс өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоохдоо нөгөө талын нутаг дэвсгэрт 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ажилласан (даатгуулсан) цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоох;
- БНКУ-д 1998 оноос хойш ажилласан (даатгуулсан) хугацаанд ногдох хуримтлалын тэтгэврийг БНКУ-ын хууль тогтоомжийн дагуу тогтоож, олгох, Монгол Улсад байнга оршин суухаар гарсан тохиолдолд Монгол Улс дахь тэтгэвэр авагчийн дандсанд тэтгэврийг шилжүүлэх;
- Энэхүү хэлэлцээрт хоёр улсын цэргийн алба хаасны тэтгэвэр хамаарахгүй байх.

Уг хэлэлцээр батлагдсанаар хоёр улсын иргэд Монгол Улс болон БНКУ-д ажилласан, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Монгол Улсын иргэд БНКУ-аас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдсэнээр тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа сайжрах юм.

Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээ юм. Хэлэлцээрийг монгол, казах болон орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж, бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байхаар тусгасан.

Олон улсын гэрээний тухай 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу талууд хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, Казахстаны талаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 30-73 тоот ноот бичгээр эцэслэн тохиролцсон хэлэлцээрийн төслийг ирүүлсэн. Мөн Монголын талаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Гадаад харилцааны яамаар уламжлуулан 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1251 дүгээр албан бичгээр Казахстаны талд эцэслэн тохиролцсон хэлэлцээрийн төслийг хүргүүлснээр талууд хэлэлцээрийн төслийн эх бичвэрийг харилцан солилцсон болно.

Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Түүнчлэн, Хэлэлцээрийн төслийг БНКУ-ын Засгийн газар 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн дэмжиж, улмаар 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 441 дүгээр тогтоолоор БНКУ-ын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын сайдад хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг олгосон.